

АУДИТЫН ТАЙЛАНГ
БЭЛТГЭСЭН:

Булган аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх
аудитор
Д.Анхбаяр

Аудитын менежер
Ж.Энхцоодол

Ахлах аудитор
П.Содном
Аудитор
Д.Даариймаа

2018 оны 11 дүгээр
сар

Уг тайланг аймаг дахь
Төрийн аудитын
газраас авч үзнэ үү:

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70342495, 70342716
утасаар
факс:70342580
дугаараар харилцана
уу

ХАЯГ:

Булган сум 5-р баг
Нутгийн удирдлагын
ордон
Өвөө № 401 тоот

Товчилсон үгийн тайлбар.....2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга, зүй, шалгуур
үзүүлэлт..... 3

**Бүлэг А. Төсвийн тухай хуулинд аймаг, сум дүүргийн
төрийн сангийн бүтцийг зааж өгсөн боловч тосгоны төрийн
сангийн тогтолцоо, нэгжийн бүтэц, чиг үүргийг хуульчилж
өгөөгүй байна.**

А.1. Аймгийн тусгай сангуудын бүртгэл тайлагналыг СТСХ-
ийн дарга, ерөнхий нягтлан бодогч, төсвийн мэргэжилтэн хариуцан
ажиллаж байгаа нь төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд
хяналт тавих гэсэн заалттай зөрчилдөж байна.....4-5

А.2. Орон нутагт тусгай сангуудын бүртгэл, тайлагнал нь
ажил ачааллаас шалтгаалан хууль журамд заасан чиг үүргийн дагуу
явагдахгүй байгаа нь төрийн сангийн зарим чиг үүрэг, ажлын
хуваарьт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.....6

А.3. Төрийн сангийн ажилтнуудын чиг үүрэг ажлын байрны
тодорхойлолттой нийцэж байгаач нягтлан бодогч болон төсвийн
мэргэжилтэн болон санхүүгийн албаны даргын өдөр тутмын ажил
үүргийн хуваарилалт тэнцвэргүй байна.....7-8

А.4. Төрийн сангийн үйл ажиллагаанд “Зөв бүртгэл”
хөтөлбөрийг боловсруулан ажиллажээ.....8-9

**Бүлэг Б. Зарим сумдад төрийн сангийн төлбөр
тооцоог хууль журмын дагуу гүйцэтгээгүй, төлбөр тооцоог
хийх эрх бүхий албан тушаалтны гарын үсгийн
баталгаагүйгээр төрийн сангаас зарлага гаргасан байна.**

Б.1. Зарим сумдад төрийн сангийн төлбөр тооцоог хууль
журмын дагуу гүйцэтгээгүй, төлбөр тооцоог хийх эрх бүхий албан
тушаалтны гарын үсгийн баталгаагүйгээр төрийн сангаас зарлага
гаргасан байна..... 10-25

Б.2. Системийг хэрэглэхэд ойлгомжтой, шаардлагатай үйл
ажиллагааны хамрах хүрээг хамарч чадсан хэдий ч гар ажиллагаа
их шаардлагатай, сарын сүүл болон эхээр ачаалал нь ихэсч гацдаг
дутагдал байна..... 26

Б.3. Төрийн сангийн дотоод хяналтаар илэрсэн алдаа зөрчил
аудитын явцад дахин давтан гарч байна.....27-28

Дүгнэлт.....29

Зөвлөмж.....30

Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал.....
Тайлан баталгаажуулсан тушаал.....
Тайлангийн хавсралтууд.....

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний аудитын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
САД	Санхүүгийн албаны дарга
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БХС	Байгаль хамгаалах сан
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГСУМС	Засгийн газрын санхүү удирдлага мэдээллийн систем
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ХЖТ	Хөгжимт жүжгийн тетр

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төсвийн Байнгын хорооны 2017 оны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов А/06 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газрын 2018 онд аудит хийх төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг явуулахдаа өөрийн нөөц үр ашигтай ашиглаж дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэрхэн биелүүлж хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгч үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын хамрах хүрээ:

Аудитыг Төрийн сангийн 2017 оны үйл ажиллагаатай холбоотой баримт материалд тулгуурлан аймгийн төрийн сан, сумдын төрийн сангууд зарим төсөвт байгууллагууд хамрагдлаа.

Аудитын арга зүй

Аудитыг Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоол, түүнийг дагалдан гаргасан эрх зүйн актуудын хүрээнд хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, санал, асуулга, шаардлагатай баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийж, зарим арга хэмжээнээс түүвэрчлэн шалгах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглагдах хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн акт, холбогдох бичиг баримтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- + Төрийн аудитын тухай хууль,
- + Төсвийн тухай хууль
- + Төвсийн тогтвортой байдлын тухай хууль
- + Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- + Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- + Шилэн дансны тухай хууль
- + Холбогдох бусад хууль, эрх зүйн акт, тогтоол, тушаал, шийдвэр

Ерөнхий мэдээлэл:

Санхүү төрийн сангийн хэлтсийн үйл ажиллагааны зорилго: Аймгийн төвсийн дунд хугацааны төсвийн төсөөлөл болон жилийн төсвийн төлөвлөгөөний төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төрийн сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, аймаг сумын төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг хэрэгжүүлэх, орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, тайлагналтыг зохион байгуулах, улс, орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг цаг хугацаанд нь тайлагнаж, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл хөтлөлт, тайлан гаргалтыг сайжруулахад оршино.

Чиг үүрэг: Татварын орлогын төлөвлөлт, татвар хураалтын ажлын зохион байгуулалт, төсвийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт болон төсвийн гүйцэтгэлийг хангах, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системийг нэвтрүүлэх, төсөвт байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд байнгын хяналт тавих зэрэг бодлогын удирдамж чиглэл, арга зүйгээр хангах үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Бүлэг А

Төсвийн тухай хуулинд аймаг, сум дүүргийн төрийн сангийн бүтцийг зааж өгсөн боловч тосгоны төрийн сангийн тогтолцоо, нэгжийн бүтэц, чиг үүргийг хуульчилж өгөөгүй байна

А.1 Аймгийн тусгай сангуудын бүртгэл тайлагналыг СТСХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч, төсвийн мэргэжилтэн хариуцан ажиллаж байгаа нь төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих гэсэн заалттай зөрчилдөж байна.

А.1.1. Монгол Улсын “Төсвийн тухай хууль” хэрэгжиж эхэлснээр тус хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэхь “Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид “төрийн сан” гэх/-оос бүрдэнэ” гэж заасны дагуу аймаг, сумын төрийн сангийн тогтолцоо, чиг үүргийг аудитын явцад хянаж үзэхэд Булган аймагт Санхүү төрийн сангийн хэлтэс, 16 сум, 1 тосгон нийт 18 төрийн сан үйл ажиллагаа явуулж байна. Хангал сумын Хялганат тосгоны төрийн сан нь орлогын 16, төсөвт байгууллагын 7, төсөл сангийн 3 дансаар санхүүгийн төлбөр тооцоог гүйцэтгэж байгаа бөгөөд Төсвийн тухай хуулинд аймаг, нийслэл, сум дүүргийн төрийн сангийн бүтцийг зааж өгсөн боловч хуулинд тосгоны төрийн сангийн тогтолцоог тусгаж өгөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 37.1 -д төрийн сангийн нийтлэг чиг үүргийг 8 заалтаар, Засгийн газрын 326 тоот тогтоолоор суманд “Санхүүгийн алба” байгуулсан бөгөөд хавсралтад санхүү албаны бүрэлдэхүүн, ажлын чиг үүргийг тусгасан, Сангийн сайдын 2015 оны 90 тушаалаар аймгийн санхүү төрийн сангийн хэлтсийн ажилтны ажил үүргийг албан тушаал бүрээр, сумдын санхүүгийн албаны ажил үүргийг тодорхой оруулан баталжээ.

Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2016 оны б/69 тоот тушаалаар санхүү төрийн сангийн хэлтсийн орон тоог хэлтсийн дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогч, төсвийн зарлагын мэргэжилтэн, нягтлан бодох бүртгэлийн бодлого хариуцсан мэргэжилтэн, төсвийн орлого хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн, төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан 2 нийт 8 орон тоотой баталж ажлын байрны тодорхойлолтод ажлын чиг үүргийг хууль журамд заасны дагуу тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалтын дансны 1-р гарын үсгийг СТХС-ийн сангийн дарга, 2-р гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч, авто замын санг ерөнхий нягтлан бодогч, байгаль хамгаалах санг төсвийн зарлагын мэргэжилтэн зурж сангуудын нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэж байгаа нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд “Төрийн сангийн нийтлэг чиг үүрэг”-д, 37.1.1-д “төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих” гэсэн заалттай зөрчилдөж байна.

Засгийн газар, сангийн сайдын төрийн сангийн чиг үүргийг баталсан тогтоол, тушаалуудад дээрх сангуудыг ямар албан тушаалтан хариуцах талаар оруулаагүй байна.

Аймгийн хэмжээнд 16 сум, 1 тосгонд санхүүгийн албаны зохион байгуулалтад орж үйл ажиллагаа явуулж байна. Засгийн газрын 326 дугаар тогтоолоор тосгонд алба байгуулах талаар тусгаагүй бөгөөд тосгонд төрийн сан, санхүүгийн алба байх эсэх, ямар чиг үүргээр ажиллах талаар хууль журамд тусгаагүй байна.

А.1.2. Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль журмууд нь бусад эрх зүйн акттай уялдаж байна.

А.2 Орон нутагт тусгай сангуудын бүртгэл, тайлагнал нь ажил ачааллаас шалтгаалан хууль журамд заасан чиг үүргийн дагуу явагдахгүй байгаа нь төрийн сангийн зарим чиг үүрэг, ажлын хуваарьт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

А.2.1 Монгол Улсын “Төсвийн тухай хуульд заасны дагуу аймаг, сумдад төрийн сангийн үйл ажиллагаа явагдаж байгаа боловч Булган аймагт 1 тосгонд төрийн сангийн үйл ажиллагаа явуулж байна. Тайлант жилд 2219 санхүүгийн

гүйлгээг хийж 3783.5 сая төгрөгийн санхүүгийн төлбөр тооцоог гүйцэтгэж төр төсвийн байгууллагын үйл ажиллагааг хангаж байна.

Гэтэл Төсвийн тухай хуулинд аймаг нийслэл, сум дүүргийн төрийн сангийн бүтцийг зааж өгсөн боловч тосгоны төрийн сангийн тогтолцоо, нэгжийн бүтцийг хуулинд тусгаж өгөөгүй, тосгоны эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.

А.2.2. Аймагт Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогч нар нь орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалт гэсэн сангуудын 1, 2 дугаар гарын үсгийг, авто замын санг ерөнхий нягтлан бодогч, байгаль хамгаалах санг төсвийн зарлагын мэргэжилтэн 2 дугаар гарын үсгийг зурж байгаа нь Төсвийн тухай хуулинд заасан чиг үүрэг, Сангийн сайдын төрийн сангийн ажилтны чиг үүргийг тусгасан тушаалтай зөрчилдөж байна.

Мөн сумдад хэрэгжиж байгаа ОНХС, СХС, ЖДҮДС, БХС зэрэг сангуудын бүртгэл тайлагналыг Засгийн газрын 326 дугаар тогтоол, Сангийн сайдын 90 дугаар тушаалд Санхүүгийн албаны ажлын чиг үүрэгт нягтлан бодогч хариуцахаар тусгасан ч Тэшиг, Баяннуур сумд төрийн сангийн мэргэжилтэн, Сэлэнгэ, Хангал, Хишиг-Өндөр сум, Хялганат тосгонд Санхүүгийн албаны дарга 2 дугаар гарын үсэг зурж бүртгэл тайлагналыг хариуцан ажиллаж байна. Энэ нь ажил үүргийн хуваарь, ажлын ачаалал зэргээс шалтгаалан сумдад харилцан адилгүй байгаа нь төрийн сангийн чиг үүрэг, ажлын хуваарьт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Хялганат тосгон нь санхүүгийн албаны ерөнхий зохион байгуулалт, чиг үүргийг барьж ажиллаж байгаа хэдий ч орон нутгийн байгууллагуудыг хариуцсан нягтлан бодогч нь эрүүл мэндийн төвийг хариуцан захирагчийн ажлын албаны төсөвт багтдаг, тусгай зориулалтын шилжүүлгийн нягтлан бодогч нь ерөнхий боловсролын сургуулийн төсвөөс цалин авч захирагчийн ажлын албанд ажил үүргээ явуулж байгаа нь тосгоны төрийн сангийн ажлын чиг үүргийг тодорхой болгох шаардлага байна.

А.3. Төрийн сангийн ажилтнуудын чиг үүрэг ажлын байрны тодорхойлолттой нийцэж байгаач нягтлан бодогч болон төсвийн мэргэжилтэн болон санхүүгийн албаны даргын өдөр тутмын ажил үүргийн хуваарилалт тэнцвэргүй байна.

А.3.1. Төсвийн тухай хуулийн 37.1, Засгийн газрын 326 тоот тогтоол, Сангийн сайдын 2015 оны 90 тушаалаар аймгийн санхүү төрийн сангийн хэлтсийн ажилтны ажил үүргийг албан тушаал бүрээр, сумдын санхүүгийн албаны ажил үүргийг тодорхой оруулан баталжээ.

Аймгийн ОНХС, ОНХО-ын дансны 1-р гарын үсгийг СТСХ-ийн дарга, 2-р гарын үсгийг төрийн сангийн ерөнхий нягтлан бодогч, БХС-гийн 2-р гарын үсгийг төрийн сангийн зарлагын мэргэжилтэн, авто замын сангийн 2-р гарын үсгийг төрийн сангийн

ерөнхий нягтлан бодогч зурж гүйлгээ хийж байгаа нь төрийн сангийн чиг үүрэгт тусгагдаагүй ажлыг ажлын байрны тодорхойлолтод тусган хэрэгжүүлж байна.

Сумдын Санхүүгийн албаны ажилтнууд чиг үүрэг ажлын байрны тодорхойлолттойгоо нийцүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа боловч ажлын ачааллыг хөнгөвчлөх зорилгоор зарим заалт хэрэгжээгүй байна.

Сангийн сайдын 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 90 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын нягтлан бодогчийн чиг үүрэг хэсгийн 2.3.3 дахь “Засаг даргын нөөц хөрөнгө, сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан, байгаль хамгаалах сан, мал хамгаалах сан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн өдөр тутмын гүйлгээнд 2 дугаар гарын үсэг зурах бүртгэл хөтлөх, тайлагналтыг хариуцах” гэсэн заалт зарим сумдад хэрэгжээгүй байна. Хишиг-өндөр, Хангал, Сэлэнгэ сумд, Хялганат тосгоны Санхүүгийн албаны дарга сангуудын 2-р гарын үсэг зурдаг, Баяннуур, Тэшиг сумын төсвийн мэргэжилтэн сангуудын 2-р гарын үсгийг зурж бүртгэлийг хариуцахаар ажлын байрны тодорхойлолт тусгасан нь төрийн сангийн чиг үүрэгтэй нийцэхгүй байна.

Орон нутгийн нягтлан бодогч нь сумын ЗДТГ, ЭМТ, ИТХ, ОНХС, СХС, ЖДҮДС, Засаг даргын нөөц хөрөнгө, БХС зэрэг 8 төрлийн сан, төсвийн байгууллага хариуцан бүртгэл тайланал, анхан шатны баримтын бүрдлийг хариуцан ажиллаж байгаагаас үзэхэд ажлын ачаалал харьцангуй их байна гэсэн нягтлан бодогч нарын санал хүсэлт их байна.

Санал асуулгаар гарсан саналаас дурдвал: Суманд Санхүүгийн алба байгуулснаар нягтлан бодогч нарын ажлын ачаалал нэмэгдсэн. Өдрийн ажилд зөвхөн хариуцаж буй байгууллагуудын гүйлгээ, судалгааг л хийдэг. Бусад үндсэн ажлуудаа хийхийн тулд заавал илүү цагаар ажиллаж байна. Илүү цагийн хөлс болон бусад нэмэгдэл авдаггүй, зөвхөн үндсэн цалингаар цалинждаг. Байгууллага шилэн дансны мэдээллээ зөвхөн нягтлан бодогч нарт даатгадаг. Байгууллагын дарга эрхлэгч нар нэвтрэх код, нууц кодоо мэдэхгүй зөвхөн нягтлан бодогч нар дарга нарын эрхээр орж тайлан татаж илгээдэг. Нягтлан бодогч нарын хариуцлага өндөр байна. Санхүүтэй холбоотой бүх мэдээлэл цахимд шилжиж байгаатай холбогдуулан ажлын ачаалал ихэссэн мөн ашиглаж буй техник хэрэгсэл дутмаг, шаардлага хангахгүйтэй холбоотой мэдээ тайлан хоцрох, дутуу хийгдэх зэрэг олон саад бэрхшээл байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилт орон нутагт үр дүн муу, зардал бага тул тайлагналт дүн нь хүрэхгүй. Иймээс шилэн дансны хуульд нэмэлт өөрчлөлт оруулах томоохон яам, тамгын газрууд тайлагнах нь зүйтэй болов уу. гэсэн санал гарсан байна.

Хэдийгээр сумдын санхүүгийн алба жишиг орон тоогоор 4 байгаа боловч сумын бүртгэл тайлагналын ажил 2 нягтлан бодогч дээр төвлөрч, нэг нягтлан бодогч 3-4 байгууллага, сангуудыг хариуцаж байгаа нь ажлын үр дүн, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа чанаргүй болж сөргөөр нөлөөлөхөөр байна. Нягтлан

бодогч, төсвийн мэргэжилтэн, санхүүгийн албаны даргын өдөр тутмын ажил үүргийн хуваарилалт тэнцвэргүй, ачаалал их байгаа тул нягтлан бодогчийн орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

А.3.2 Төрийн сангийн чиг үүрэг нь бусад төрийн байгууллагуудын ажлын чиг үүрэгтэй давхцаагүй байна.

А.4. Төрийн сангийн үйл ажиллагаанд “Зөв бүртгэл” хөтөлбөрийг боловсруулан ажиллажээ.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Зөв бүртгэл” хөтөлбөрийг 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр жил бүр төлөвлөгөө боловсруулан ажиллахаар төлөвлөжээ.

Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтөлөлт, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлагналын олон улсын хэрэгжилтийг сайжруулж, нягтлан бодох бүртгэлийн бодлого арга зүйг боловсруулах, түүнийг нэвтрүүлэх, удирдлага, нягтлан бодогч, эд хариуцагчдын мэдлэг чадвар, туршлагыг дээшлүүлэх, тэдгээрийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх зорилготой хөтөлбөр боловсруулжээ.

“Зөв бүртгэл” хөтөлбөрт дараах 4 үндсэн зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Зорилт 1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэх, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд оршиж байгаа зөрчил дутагдлыг арилгаж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Зорилт 2. Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл, тайлангийн стандарт горим, төлөвлөлтийн арга зүйг мөрдөх талаар хүлээх хариуцлагыг дээшлүүлж, удирдлагын шийдвэр гаргахад санхүүгийн болон дотоод мэдээ, тайлангийн ач холбогдлыг нэмэгдүүлэх

Зорилт 3. Бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд орчин үеийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдээллийн технологи, сүлжээ, программ хангамжийг бүрэн ашиглах нөхцөл бүрдүүлж ажиллах

Зорилт 4. Санхүү, бүртгэлийн ажилтны мэдлэг чадварыг үе шаттай дээшлүүлэх, удирдах ажилтнуудад санхүүгийн мэдлэг олгох зорилтын хүрээнд 24 ажил төлөвлөн ажиллажээ.

2017 онд “Зөв бүртгэл” хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаанд Монгол Улсын гавьяат эдийн засагч, доктор, профессор Р.Батжаргал багшийг урьж “Шинэ эриний нягтлан бодогч” сэдэвт лекц, “Нягтлан бодогчийн ёс зүй” сэдэвт сургалт, Монголын нягтлан бодогчдын хүрээлэнтэй хамтарч нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг таниулах үйл ажиллагаанд сумын санхүүгийн албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтэн, байгууллагуудын нягтлан бодогч 150 гаруй хүн оролцжээ.

Сангийн яамтай хамтран “Орон нутгийн төрийн сангийн ажилтнуудыг чадавхижуулах нь” сургалтыг 7 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд аймгийн төвд зохион байгуулж аймаг, сумын төрийн сангийн мэргэжилтнүүд хамруулсан байна.

Мөн “Тод санхүү” нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө өгөх төв сургалтын байгууллагатай хамтран аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарт зориулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт боловсруулах, өөрчлөлт орсон стандартууд, Зөрчлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх сургалт, жижиг дунд аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч, нягтлан бодогч нарт санхүүгийн тайлангийн программ дээр ажиллах сургалтад 183 хүн хамрагдсан байна.

“Шилдэг санхүүгийн алба”, “Шилдэг нягтлан бодогч” шалгаруулах болзол боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж батлуулан 2017 онд ажлыг дүгнэн шалгаруулсан байна.

Хөтөлбөр боловсруулсанаар дараах ахиц гарсан байна.

Нягтлан бодох бүртгэлийг хөгжүүлэх, сайжруулах чиглэлээр тодорхой хэмжээний хөрөнгийг орон нутагт төсөвлөж зарцуулдаг болсон.

-Сумдын санхүүгийн алба, нягтлан бодогчдын үйл ажиллагааг үнэлж дүгнэж шилдгийг шалгаруулах болзолтой болсноор тэдний идэвхи санаачилга нэмэгдсэн.

-Аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн тайлангийн ирц өссөн байна.

Бүлэг Б Байгууллагын тамга, нягтлан бодогчийн гарын үсэггүй баримтаар төлбөр тооцоог гүйцэтгэсэн байна.

Б.1. Зарим сумдад төрийн сангийн төлбөр тооцоог хууль журмын дагуу гүйцэтгээгүй, төлбөр тооцоог хийх эрх бүхий албан тушаалтны гарын үсгийн баталгаагүйгээр төрийн сангаас зарлага гаргасан байна.

Б.1.1 Аймагт төрийн сангийн төлбөр тооцоог 19 төрийн сангийн мэргэжилтэн Төрийн санд байршсан 726 дансаар санхүүгийн төлбөр тооцоог гүйцэтгэн явуулж байна.

Санхүүгийн төлбөр тооцоог хийхдээ төсвийн захирагч нар нь гарын үсгийн баталгааг холбогдох журмын дагуу эрх бүхий хүмүүсээр батлуулж төсвийг захиран зарцуулах журамтай гэтэл Сэлэнгэ сумын төсөвт байгууллагын 1, 2 дугаар гарын үсгийн баталгааг журмын дагуу хийсэн ч нотариатаар батлуулаагүй, ОНХС, СХС, БХС, ЖДҮДС, сонгуулийн данснаас төлбөр тооцоог хийх эрх бүхий албан тушаалтны гарын үсгийн баталгаагүйгээр төрийн сангаас зарлага гаргасан нь Засгийн газрын 2013 оны 116 тоот тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.3 “Төсвийн байгууллага гарын үсгийн баталгааг энэхүү журмын 3 дугаар хавсралтын ТТ-3 маягтаар үйлдэн нотариатаар батлуулан 1,2 дугаар

гарын үсэг зурах эрх олгосон болон томилогдсон шийдвэр, энэхүү журмын 7.2-т заасан зөвшөөрлийн хамт харьяа Төрийн санд хүргүүлнэ.”, 7.13.5 дахь “энэхүү журмын 7.1,7.2,7.3-т заасан бүрдэл болоогүй гарын үсгээр гүйлгээ хийх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Бугат сумын ИТХ-ын 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдөр бичигдсэн 6 төрлийн 2716.0 мянган төгрөгийн төлбөрийн хүсэлтийг 2017 оны 06 дугаар сарын 23-нд төрийн сангийн системд гүйлгээг хийсэн нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.2 “Төрийн сан нь төрийн сангийн төлбөр тооцооны системд бүртгэгдсэн зарлагын гүйлгээг төсвийн байгууллагын төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлт, хяналтын хуудсыг үндэслэн баталгаажуулж, ажлын 3 хоногт багтаан эцсийн төлбөр гүйцэтгэх үүргийг хариуцна.”, 8.10 дахь **“Төсвийн байгууллагын ТТ-1, ТТ-2 маягтаар бичигдсэн төлбөрийн хүсэлт нь бичигдсэн өдрийг оролцуулан ажлын 3 хоногт хүчинтэй.”** гэж заасныг зөрчсөн зөрчил илэрлээ.

Төсвийг захиран зарцуулахдаа төсөв захирагчийн гарын үсэггүй, байгууллагын тамга тэмдэг дараагүй төлбөр тооцооны маягтаар гүйлгээг хийсэн байна. Тухайлбал Булган сумын төрийн сан нягтлан бодогч, байгууллагын тамга тэмдэг дараагүй 72207.9 мянган төгрөгийн 31 гүйлгээ, Сэлэнгэ сум нягтлан бодогчийн гарын үсэггүй 24537.0, Могод сум 7 гүйлгээний 11475.0, Хишиг-Өндөр сум 2 гүйлгээний 1744.9 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.13. дахь “Дараах тохиолдолд зарлагын гүйлгээ гаргахыг хориглоно:”, 7.13.5. “энэхүү журмын 7.1, 7.2, 7.3-т заасан **бүрдэл болоогүй гарын үсгээр гүйлгээ хийх;**”-ийг **хориглоно** гэсэн заалтыг зөрчсөн байна.

Сэлэнгэ сумын төрийн сангаар хийгдсэн 6 төсөвт байгууллагын 17 гүйлгээний 14031.0 мянган төгрөгийн төлбөрийг гүйцэтгэхдээ төсвийн мэргэжилтэн гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулаагүй нь төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.6 дахь **“Төрийн сан нь төсөвт байгууллагын төлбөрийг гүйцэтгэхдээ үндэслэх баримтуудыг хяналтын хуудастай тулган төрийн сангийн тэмдэг дарж, төлбөрийн хүсэлтэн дээр гарын үсэг зуран тэмдэг дарж баталгаажуулан төсвийн байгууллагад 1 хувийг өгнө. Төлбөрийн хүсэлтийн 1 хувь Төрийн санд үлдэнэ.”** гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тус сумын Санхүүгийн албаны дарга нь төрийн санд хийгдсэн гүйлгээг хянаж гүйлгээний тэмдэг дарж, гарын үсэг зурж баталгаажуулдаг, төрийн сангийн мэргэжилтэн нь хяналт хийдэггүй, гүйлгээнд гарын үсэг зурж, тэмдэг дардаггүй байна. Төрийн үйл ажиллагааны журмын 12.2 “Төрийн сангийн мэргэжилтэн тус бүр тусгай дугаар бүхий өөрийн баталгааны тэмдэгтэй байна.” гэсэн заалтыг зөрчин Санхүүгийн албаны дарга эзэмшиж байгаа зөрчил байна.

Төрийн сангийн зарлагын жагсаалтыг Бугат, Сэлэнгэ сумд дараа сард, Хангал сум, Хялганат тосгон 10 хоногт тулган хянаж байгаа нь Төрийн сангийн үйл

ажиллагааны журмын 8.12 Төрийн санд үлдэх төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлт, хяналтын хуудсыг тухай өдрийн зарлагын гүйлгээний жагсаалттай тулгаж, өдөр тутмын мемориалын баримтад хавсаргана”, **11.1 дэхь “Төрийн сан өдөр тутмын төлбөрийн баримтыг тухай өдрийн зарлагын гүйлгээний жагсаалттай дараагийн ажлын өдөрт багтаан хянаж тулгасан байна.”** гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, төрийн сангийн төлбөр тооцооны хяналт сул, зарлагын жагсаалтыг журамд заасан хугацаанд хийж тулган баталгаажуулаагүй зөрчил байна.

Сангийн сайдын 2014 оны 95 тоот тушаалаар баталсан Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системийг аймгийн төрийн санд 4 суманд санхүү албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн гэсэн 2 хэрэглэгч нийт 36 ашиглаж байна.

Дээрх хэрэглэгчид ээлжийн амралттай, түр чөлөөтэй үед программд нэвтрэх нэр, нууц үгийг түр хугацаагаар эрх шилжүүлэхэд маягт, албан бичгээр шилжүүлэх бөгөөд Сэлэнгэ сумын Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн нар 2017 оны ээлжийн амралтын хугацаанд эрх шилжүүлээгүй байгаа нь Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд мөрдөх журмын 2.4 дэхь “системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчдийн **ээлжийн амралт**, гадаад болон дотоод томилолт, хүүхэд асрах чөлөөтэй, түр хугацааны чөлөөтэй байх хугацаанд **системийн нэр нууц үгээ шилжүүлэх тохиолдолд харьяа нэгжийн удирдах албан тушаалтны холбогдох тушаал шийдвэрийг үндэслэн эрхийг шинэ хэрэглэгчид шилжүүлж, тухай бүр харьяа санхүү төрийн сангийн хэлтэст албан бичгээр мэдэгдэнэ.**” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Сэлэнгэ сумын Санхүүгийн алба орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, байгаль хамгаалах сан, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн төлбөр тооцоо хийх эрх бүхий албан тушаалтны гарын үсгийн баталгаа байхгүй төрийн сангаас төлбөр гүйцэтгэсэн, зарлагын гүйлгээний жагсаалтыг сард нэг удаа тулган баталгаажуулдаг, байгууллагын даргын гарын үсэг, тамга тэмдэггүй 5 гүйлгээний 3237.0, нягтлан бодогчийн гарын үсэггүй 24537.0 мянган төгрөгийн гүйлгээг хийсэн, системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчид ээлжийн амралттай, түр чөлөөтэй үед программд нэвтрэх нэр, нууц үгийг журмын дагуу шилжүүлээгүй, Төрийн сангийн мэргэжилтэн төлбөр тооцоог хийхдээ төрийн сангийн тамга, гарын үсэг зурж баталгаажуулаагүй 17 гүйлгээний 14031.0 мянган төгрөгийн зөрчил, төсвийн мэргэжилтний хийсэн төлбөр тооцоог Санхүүгийн албаны дарга гүйлгээний тамга дарж, гарын үсэг зурж баталгаажуулдаг зэрэг зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах алба шаардлага, Санхүүгийн албаны даргад хариуцлага тооцох албан тоотыг Сумын засаг даргад хүргүүлээ.

Б.1.2. Булган аймгийн төрийн сан мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд дараах зүйлсийг бүртгэж тайлагнадаг байна. Үүнд:

- Төрийн сангийн харилцахын үлдэгдэл, байгууллага, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сан, харилцах дансдын үлдэгдэл, ОНӨҮГ-ууд, төсөл сөнгийн төгрөгийн харилцах дансдын үлдэгдэл
- Кассанд байгаа бэлэн мөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2016 оны эцэст 5803.2 сая төгрөг байснаас 2017 оны жилийн эцэст 6860.9 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 88.7 хувь буюу 5869.2 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2017 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн харилцах
Кассад байгаа бэлэн мөнгө	9.2	1.1	1.1		
Банкинд байгаа бэлэн мөнгө	5794.0	6859.7			
Төрийн сангийн харилцах	5263.0	5863.2			5863.2
Арилжааны банк	530.9	996.5		996.5	
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	5803.3	6860.9	1.1	996.5	5863.2

Төрийн санд байршиж буй харилцах дансдын үлдэгдлийг сумдаар нь харуулбал: /сая.төг/

№	Сумын нэр	Өмнөх он	Тайлант он
1	Булган аймаг /СТСХ/	3738.2	4414.9
2	Баян-Агт	71.9	47.5
3	Баяннуур	22.5	23.6
4	Бугат	55	90.6
5	Булган	219.8	163.3
6	Бүрэгхангай	45.9	133.5
7	Гурванбулаг	112.7	162.3
8	Дашинчилэн	106.8	152.8
9	Могод	39.6	55.2
10	Орхон	48.5	77.3
11	Рашаант	66.3	60.9
12	Сайхан	107.1	91.5
13	Сэлэнгэ	478.2	165.5
14	Тэшиг	17.1	33.3
15	Хангал	38.9	57.5

16	Хишиг-Өндөр	66.5	93.4
17	Хутаг-Өндөр	26.5	30.9
18	Хялганат тосгон	1.6	11.2
Нийт		5263.1	5863.2

Аймгийн төрийн сан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4414.9 сая төгрөгийн үлдэгдлийн Булган хөгжил сан 257.2, авто замын сан 88.9, цэргийн дүйцүүлэх алба 12.3, байгаль хамгаалах сан 12.9 мал хамгаалах сан 135.7, гамшгаас хамгаалах сан 80.9, орон нутгийн хөгжлийн сан 146.3 сая төгрөг тус тус байна.

Аймгийн хэмжээнд мөнгөн хөрөнгийн 2017 оны эцсийн үлдэгдэл 6860.9 сая төгрөгийн 7.7 хувь буюу 513.8 төсөвт байгууллагын, 62.8 хувь буюу 4158.8 төрийн сангийн, 11.3 хувь буюу 744.6 орон нутгийн өмчит газрын, 18.2 хувь буюу 1196.5 сая төгрөг нь төсөл сангуудын мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 760.7 сая төгрөгөөс аймгийн 80-н жилийн хандив 246.9 сая төгрөгийг тайланд тусгасан байна. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5863.2 сая төгрөгийн 97.2 сая төгрөг нь сумдын давсан орлого, 2262.5 сая төгрөг нь аймгийн давсан орлого болон төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Төсөл сангийн шугамаар иргэдэд олгож байгаа зээлийн эргэн төлөлт мөн эргэн төлөгдөх нөхцөлөөр жижиг дунд үйлдвэрлэл дэмжих зорилгоор СХС-гаас олгосон зээлтэй холбоотой авлагын эхний үлдэгдэл 4175.1 сая төгрөгөөс тайлант онд 104.6 сая төгрөг барагдсан байна. Тайлант онд зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс Бугат, Гурванбулаг, Орхон, Тэшиг сумдууд огт зээл олгоогүй бусад сумдууд 165 иргэнд 694.3 сая төгрөгийн зээл олгож авлагын эцсийн үлдэгдэл 4070.7 сая төгрөг байна. Үүний 1766.5 сая төгрөгийн 546 иргэнтэй холбоотой сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хугацаа хэтрэлттэй аймгийн хэмжээнд 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө эргэлтэнд ороогүй байна.

Б.1.3 Төсөл сангийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажлууд үр дүн муу, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах эрсдэл байна.

Тайлант оны төсөвт аймгийн ИТХ-ын 05 дугаар сарын 12-ны өдрийн 04, 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 дугаар хуралдаанаар хоёр удаа тодотгол хийжээ.

УИХ-ын 29 дүгээр тогтоолоор 2017 оны төсвийг тодотгон баталж зардлыг хэмнэх, үр ашгийг дээшлүүлэхээр болсны дагуу төрийн албан хаагчдын цалин хөлсийг царцааж, зэрэг дэв ахиулахгүйгээс гадна зөвхөн эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдлын салбараас 2 албан хаагч тэтгэвэрт гарах тохиолдолд 1 албан хаагчийг (2:1) нөхөн томилохыг 2017-2019 онд хийхээр чиглэл болгосонг үндэслэн дараах нөхцөл шалтгаанаар төсөвт тодотгол хийхээр болсон байна.

- УИХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний тогтоолоор улсын төсвийг тодотгон баталсан,
- Төсөвт байгууллагуудын 2016 онд үүссэн болон 2017 онд үүсэхээр тооцоологдсон урсгал зардлын өрийг барагдуулах,
- Төсөвт төвлөрүүлэх орлого нэмэгдэж, ОНХС-гийн эх үүсвэр өөрчлөгдсөн

ИТХ-ын 04 дүгээр хуралдаанаар 2017 оны төсөвт ХХОАТ-ын буцаалтыг 24.8, ОНХС-гийн шилжүүлгийг 232.1, тусгай зориулалтын шилжүүлгийг 19.4 сая төгрөгөөр тус тус бууруулж оны эхний үлдэгдлээс 1402.3 сая төгрөг нэмж орохоор тусган нийт орлогыг 1175.6 сая төгрөгөөр буюу батлагдсан төсвөөс 2.4 хувиар нэмэгдүүлж, сумдын ОНХС-д олгох санхүүгийн дэмжлэгийг 88.1 сая төгрөгөөр буюу 13.4 хувиар бууруулж төсөвт байгууллагуудын зардлыг 1087.6, улсын төсвийн төвлөрүүлэх шилжүүлгийг 176.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг баталсан төсвөөс 2.4 хувиар буюу 1175.5 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

УИХ-ын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор 2017 оны төсвийг ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээтэй холбогдуулан төсөвт тодотгол хийсэн байна. Уг тодотголоор суурь зарлагыг 1000.0 сая төгрөгөөр нэмж, аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 290.4 сая төгрөг болгон баталсны дагуу аймгийн төсөвт дараах өөрчлөлтийг оруулсан байна.

Тодотголоор төсөвт байгууллагын өөрийн орлогыг 61.3, тусгай зориулалтын шилжүүлгийг 630.0, оны эхний үлдэгдлийг 873.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь өмнөх тодотголын дүнгээс 3.1 хувиар буюу 1564.4 сая төгрөгөөр орлогыг, төсөвт байгууллагуудын урсгал зардлыг 1966.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж улсын төсвийн төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг 402.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

**Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг
хүснэгтээр харуулбал:**

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	/ сая.төг/ Гүйцэтгэлээрх нийт дүнд эзлэх хувийн жин
НИЙТ ОРЛОГО	18785.7	21034.7	2249.0	112	100%
Татварын орлого	18237.1	20509.7	2272.6	112.5	97.5%
Татварын бус орлого	528.6	476.2	-52.4	90.1	2.3%
Хөрөнгийн орлого	20.0	48.8	28.8	243.9	0.2%

Нийт орлого 2249.0 сая төгрөгөөр буюу 112.1 хувиар давж биелсэн нь өмнөх оноос 949.4 сая төгрөгөөр өссөн, орлогыг нэр төрлөөр авч үзвэл жигд ханган биелүүлээгүй буюу 15 нэр төрлийн 2615.3 сая төгрөгөөр давж биелсэн бол 10 нэр төрлийн орлого 366.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Орлогын төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудыг нэр төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО	13554.7	16170.1	2615.3	119.3
Хөрөнгийн орлого	9.1	104.5	95.4	1145.9
Шууд бус орлого	546.7	727.1	180.4	133.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	380.0	385.2	5.2	101.4
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	254.6	272.5	17.9	107.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	65.9	74.2	8.3	112.7
Ашигт малтмалаас бусад байгалийн нөөц ашигласны зөвшөөрөл олгох	130.0	136.6	6.6	105.1
Газрын төлбөр	221.0	305.1	84.1	138.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	26.2	51.4	25.2	196.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	11859.3	13966.2	2107.0	117.8
Байгалийн ургамал ашигласны төлбөр	1.2	2.1	0.9	173.7
Хувьцааны ногдол ашиг	13.2	38.4	25.2	290.4
Бусад орлого	7.5	16.7	9.2	222.3
Түрээсийн орлого	20.0	24.6	4.6	123.0
Хүүгийн орлого	0.0	16.6	16.6	#DIV/0!
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	20.0	48.8	28.8	243.9

Татварын орлогоор 2017 онд аймгийн төсөвт 18237.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 20509.7 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 2272.6 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ. Ус рашааны нөөц ашигласны төлбөр 2106.9, газрын төлбөр 84.1, шууд бус орлого 180.5 сая төгрөгөөр харьцангуй их хэмжээгээр давж биелсэн нь орлогыг бодиттой төлөвлөөгүй нь харагдаж байна.

Аж ахуйн нэгжийн ус ашигласны татварын орлогыг
төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

Д/д	ААН-ийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
1	Өгөөж баян хангай	31.6	24.7	-6.9	78.2%
2	Хүслэмж	4.7		-4.7	0.0%

3	ГБНБ	73.6	54	-19.6	73.4%
4	Мондолимет	450	107.3	-342.7	23.8%
5	Хосхас	36.9	33.4	-3.5	90.5%
7	Хамтын эх булаг	18.1	5.7	-12.4	31.5%
8	Шарнарст	8		-8	-100.0%
9	Эрдэнэт үйлдвэр	11100	13550	2450	122.1%
10	ЭДЦС	70	80.8	10.8	115.4%
11	Заамар гоалд		2.8	2.8	-100.0%
12	Ориент майнинг инвэстмент		7.2	7.2	-100.0%
13	Баянгол эко заамар		7	7	-100.0%
14	Эко алтан заамар		30.3	30.3	-100.0%
15	Төсөлч		8	8	-100.0%
16	Цагаан уулын магнит		30.9	30.9	-100.0%
17	Тэргүүн майнинг		0.4	0.4	-100.0%
Нийт		11792.9	13942.5	2149.6	118.2%

2017 оны усны төлбөр нийт дүнгээр биелж байгаа ч уул уурхайгаас орох усны төлбөрийг дутуу төлөвлөсөн байна. Тухайлбал: “Цагаан уулын магнит” ХХК 30.9, “Эко алтан заамар” ХХК 30.3, Ориент майнинг инвэстмент 7.2 сая төгрөг зэрэг төсөвт төлөвлөөгүй 86.6 сая төгрөгийн орлого оржээ.

Эрдэнэт үйлдвэр 2450.0 сая төгрөгийг төлөвлөснөөс илүү оруулсан бол Бүрэгхангай сумын “Монполимет” ХХК 342.7, “ГБНБ” ХХК 19.6, “Хамтын эх булаг” ХХК 12.4 сая төгрөгийг төлөвлөснөөс дутуу оруулсан байна.

Тайлант онд тасарсан орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО	5626.1	5260.1	-366.0	93.5
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	4188.0	4138.3	-49.7	98.8
Үйл ажиллагааны орлого	214.0	128.5	-85.5	60.0
Бууны албан татвар	65.9	60.4	-5.5	91.7
Улсын тэмдэгтийн хураамж	189.0	151.7	-37.3	80.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	145.1	89.8	-55.3	61.9
Бусад татвар	2.0	0.0	-2.0	0.0
Ойн нөөц ашигласны төлбөр	331.7	310.7	-21.0	93.7
Нохойн татвар	2.5	0.7	-1.8	27.1

Торгуулийн орлого	402.5	355.6	-46.9	88.4
Бусад орлого	85.4	24.3	-61.1	28.5

Цалин, хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлого 49.7, үйл ажиллагааны орлого 85.5, улсын тэмдэгтийн хураамж 37.3, хог хаягдлын үйлчилгээний хураамж 55.3, торгуулийн орлого 46.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Тасарсан орлого болох торгуулийн орлого 402.5 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 355.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 46.9 сая төгрөгөөр тасарсан байна. Аймгийн Цагдаагийн газрын бэлэн бус торгуулийн машинаар 2017 онд 543.6 сая төгрөгийн торгууль бүртгэгдсэн, торгуулийн орлогыг оруулах талаар тодорхой хариуцсан газар байхгүйгээс орлого тасарч, тооцоогоор торгууль бичигдсэн 200.0 сая төгрөг төсөвт төвлөрөөгүй байна. Тухайлбал: Баяннуур сумын хүү торгуулийн орлогыг оны эхэнд 30.1 сая төгрөгөөр баталж тодотголоор 10.0 сая төгрөг болгон бууруулан баталжээ. Орлогыг анх төлөвлөхдөө 2016 онд 15.0 сая төгрөг бэлэн бус торгуулийн машинаар бичигдсэн торгуулийг орохоор тооцон төлөвлөсөн, 2017 онд 23.4 сая төгрөгийн торгууль бичигдсэн ч 9.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй нийт 29.3 сая төгрөг сумын төсөвт орох боломж байна.

Аймгийн төсвийн нийт зарлага:

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Аймгийн 2017 оны төсөв батлах тухай” 03 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн зарлагын нийт дүн, төсөв захирагчдын төсвийн жилд зарцуулах зардлын дүнг 57909.1 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн санд улсын төсвөөс авах орлогын шилжүүлгийг 1977.0 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн 28925.2 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсвийн зарлагыг төлөвлөхдөө үндэслэл муутай төлөвлөсөн байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тушаалаар “Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай” гэж заасныг зөрчин баяр наадмын зардлыг 40.0 сая төгрөгөөр хэтрүүлэн аймгийн ОНХС-гаас 50.0 сая төгрөгийг зарцуулах,
- Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг зөрчин зураг, төсөв, эдийн засгийн тооцоолол, хэрэгжүүлэх ажлын төлөвлөлт, хөтөлбөргүйгээр нийт 6 төсөл арга хэмжээнд 1638.8, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх

арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлангах журам”-ыг тус тус зөрчин БХС-гаас 5 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд 61.5 сая төгрөгийг зарцуулах,

- Төсвийн тухай хуулийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчин хэзээ, хэрхэн, юунд зарцуулах нь тодорхойгүй шаардлагатай үед зарцуулах зардалд 78.2 сая төгрөгийг БХС-гаас зарцуулахаар тус тус төлөвлөн баталсан байна.

Аймгийн төсвийн нийт зарлага 2017 оны жилийн эцсийн байдлаар 57908.9 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 53941.9 сая төгрөгийн буюу 93.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

2017 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Эзлэх хувь
1	Аймгийн Засаг дарга	28125.4	24299.5	45.2
2	БСШУсайдын	25151.3	24844.8	46.3
3	БХБсайдын	241.6	241.1	0.4
4	НХХсайдын	162.4	162.4	0.3
5	Эрүүл мэндийн сайдын	4228.4	4213.2	7.8
	ДҮН	57908.9	53941.9	

Аймгийн ТЭЗ-ийн төсвийн зарлагын гүйцэтгэлийг зориулалтаар авч үзвэл нийт зарлагын 45.2 хувь аймгийн Засаг дарга, 46.3 хувийг БСШУСайдын ТЗШ, 7.8 хувийг Эрүүл мэндийн сайдын ТШЗ зарцуулсан байгаа нь нийт зарлагын 99.3 хувийг эзэлж байна.

Нийт зардалд бараа үйлчилгээний зардал 39626.6 сая төгрөг буюу 73.5 хувь, хөрөнгийн зардал 4299.9 сая буюу 7.9 хувь, татаасын зардал 34.5 сая төгрөг буюу 0.06 хувь, урсгал шилжүүлэг 9052.5 сая төгрөг буюу 16.8 хувийг тус тус эзэлж байна. 2017 оны төсвийн хэтрэлт хэмнэлтийг зардлын зүйл ангиар авч үзвэл:

- Цалин, шимтгэл, тогтмол зардал, хоол зэрэг нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, хангамж, бараа материалын зардал зэрэг урсгал зардлуудыг батлагдсан төлөвлөгөөнөөс 1033.0 сая төгрөгөөр, нийгэмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал нь 33.8 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 1245.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Төсөл сангуудын зарцуулалтын талаар:

Аймгийн авто замын:

Булган аймгийн авто замын сан “Булган сумын зам засвар арчлалтын ажлыг чанартай хийж гүйцэтгэх” эрхэм зорилго, эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Авто замын сан нь 2017 оны эхэнд 203.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, АТБӨЯХА татвараас 254.6, зам ашигласны төлбөр хураамж 80.0 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөж үйл ажиллагааны болон зам ашигласаны хураамжаас 62.6, АТБӨЯХА татвараас 245.9 сая төгрөг төвлөрүүлж, замын сангийн төсөл арга хэмжээнд 422.7 сая төгрөг зарцуулж 88.9 сая төгрөгний үлдэгдэлтэй байна. Авто замын сангийн хөрөнгийг аймгийн 2017 оны авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

Булган-Орхон сумын чиглэлийн хатуу хучилттай замын зураг төсвийн үнэ 10.0 сая төгрөгийг “Гео зураглал” ХХК шилжүүлж авлага үүсгээгүй, ажил эхлээгүй, Булган сумын зам засварт 25.0 сая төгрөгийг аймгийн ЗД-ын шийдвэрээр Булган сум руу эрх шилжсэн юу хийсэн тодорхойгүй, тайлан аваагүй байна.

Булган сумын авто зам, замын байгууламжийн шинэчлэлийн инженерийн зураг төсөв боловсруулах ажлын зураг төсвийн үнэ 34.2 сая төгрөгийг “Тарваченбүүлэн” ХХК шилжүүлсэн бүртгэлгүй, Булган-Орхон сумын чиглэлийн хатуу хучилттай замын зураг төсвийн үнэ 10.0 сая төгрөгийг “Гео зураглал” ХХК шилжүүлсэн байна. Цаашид зураг төсвийн үнийг хийгдэх ажлын төсөвт тусгаж санд буцаан төвлөрүүлдэг байх шаардлагатай байна.

Аймгийн ОНХС:

Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ажлуудыг аймгийн ИТХ-ын 2016 оны 3 дугаар хуралдааны 03/03 тоот тогтоолын хавсралтаар хөрөнгө оруулалтын 4 ажилд 668.0, тоног төхөөрөмжийн 2 ажилд 55.0, хөтөлбөр төсөл арга хэмжээний 4 ажилд 238.0 сая төгрөгийн нийт 961.0 сая төгрөгийг батлуулжээ. Тогтоолоор хөрөнгө оруулалтын ажлыг 6 төсөл арга хэмжээнд 788.8 мянган төгрөг болгон нэмэгдүүлэн нийт 1081.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тодотгол хийгдэн баталж өмнөх тогтоолоос хөрөнгө оруулалтын 2 ажлын 120.8 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэгдүүлж нийт 12 ажил хийгдэхээр баталсан байна.

“Эрүүл мэндийн хөтөч” хөтөлбөрийн ажилд 17.5, “Оюунлаг Булган” хөтөлбөрийн хэрэгжилтэд 34.1, аймгийн баяр наадмын ажилд 50.0 сая төгрөгийг тус тус санхүүжүүлж ажилласан боловч ОНХС-гаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний ажлуудын хэрэгжилт санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, бараа материал болон үндсэн хөрөнгийг тухайн байгууллага тайлан бүртгэлдээ тусгаагүй байна.

Тухайлбал: Эрүүл мэндийн газар нь аймгийн ЗД-ын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/136 тоот захирамжын дагуу “Эрүүл мэндийн хөтөч” хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх сургалт үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан боловч ОНХС-гаас санхүүжүүлсэн 17.5 сая төгрөгийн материалыг, мөн 29.9 сая төгрөгийн “В”, “С” вирусын лабороторийн хэрэгслийг нийт 47.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, материалыг байгууллагын данс бүртгэл тайланд тусгаагүй, дотоод

хяналт хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж ажилласан тухай ажлын тайлан байхгүй, эм болон эмийн хэрэгслэл тараасан тараалтын баримт дутуу, “Эрүүл мэндийг дэмжигч” болзол уралдааны 1.5 сая төгрөгийн ажил хийгдээгүй байхад санхүүжилтийг олгосон, БСУГ нь 5.0 сая төгрөгийн ном худалдан авч 16 сумын соёлын төвд тараасан гэх боловч Баян-Агт сумын соёлын төв 0.25, Могод сумын соёлын төв 0.25, Бүрэхангай сумын соёлын төв 0.25, нийт 3 сум 0.75 сая төгрөгийн ном орлогод аваагүй байна.

Цаашид ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг ОНХС-гийн зарцуулах журмын 4.2, 4.5, 9.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх, хяналт тавьж ажилласан тухай ажлын хэсгийн тайлан, ажлын хэрэгжилтийг тайлагнаж худалдан авсан бараа материал болон үндсэн хөрөнгийг холбогдох албан газруудын тайлан балансад бүртгүүлэх төсөл арга хэмжээг хариуцан зохион байгуулж байгаа албан хаагчдын ажлыг сайжруулах, ОНХС-гийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр дүнтэй зарцуулж байх талаар анхаарч ажиллах зарцуулалтанд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Сумдын ОНХС:

ОНХС-гаас Булган аймгийн 16 суманд нийт 567.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж 15 сумын санхүүжилтийг бүрэн олгосон бол Булган сумын санхүүжилтийг 13.5 сая төгрөгөөр дутуу буюу нийт 553.9 сая төгрөг санхүүжилт олгосон байна.

Сумдын ОНХС нь 2017 оны эхний үлдэгдэл 741.6 сая төгрөг дээр ОНХС-гаас санхүүжүүлсэн 553.9 сая төгрөг нийт 1295.5 сая төгрөгийн эх үүсвэртэйгээр 175 төсөл арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Тэшиг, Хангал, Булган сум орон нутгийн хөгжлийн сангаас Цагдаагийн бэлэн бус торгуулийн машин худалдан авахаар 10.3 сая төгрөг баталж 10.2 сая төгрөгийн санхүүжилт олгож худалдан авсан, мөн Хишиг-Өндөр сум 2.5 сая төгрөгөөр ахмадын кабинетад массажны тоног төхөөрөмж, Могод сум 1.4 сая төгрөгөөр олон нийтийн цагдаагийн цалин олгосон, 2.0 сая төгрөг автомашины засвар, 1.0 сая төгрөгөөр Соёлын төвийн дуу гаргалтын тоног төхөөрөмж, Сайхан сум машины сэлбэгт 2.0 сая төгрөг, Сийлбэртэй гэр 17.5 сая төгрөг, Онцгой байдлын багаж 1.3 сая төгрөгөөр тус тус худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.1-д “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр арга, хэмжээ” гэж заасныг зөрчсөн байна. Сумдад ОНХС-г төсөл хөтөлбөр нэрээр батлан зориулалтын бус зүйлд зарцуулах эрсдэл байгааг анхаарч төлөвлөлт, зарцуулалтанд хяналтыг сайжруулах нь зүйтэй байна.

Булган сумын ОНХС-гаас Хот тохижилтийн ангид нийтийн эзэмшлийн зориулалттай олон үйлдэлт трактор худалдан авахаар 34.9 сая төгрөгөөр баталж

худалдан авалт хийсэн ч дагалдах хэрэгсэл болох ногоон байгууламж услах тоног төхөөрөмж, давс цацах зориулалтай тоног төхөөрөмж дутуу нийлүүлснээс 17.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үлдэгдэл санхүүжилт болох 17.5 сая төгрөгийг өглөгт тусгаагүй, хөрөнгийг орлогод аваагүй нь НББ-ийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг зөрчиж байна.

Байгаль хамгаалах сан:

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө зураг, төсөв, эдийн засгийн тооцоолол, хэрэгжүүлэх ажлын төлөвлөлт, хөтөлбөргүйгээр нийт 6 төсөл арга хэмжээнд 1638.8 сая төгрөгийг, Төсвийн тухай хуулийн 29.4 дэхь заалт, мөн Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлангах журам”-ыг тус тус зөрчин 5 төсөл, хөтөлбөр арга хэмжээнд 61.5 сая төгрөгийг зарцуулахаар аймгийн ИТХ-аар батлуулж, дээрх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна. Төсвийн тухай хуулийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчин хэзээ, хэрхэн, юунд зарцуулах нь тодорхойгүй шаардлагатай үед зарцуулах зардалд 78.2 мянган төгрөгийг баталж 12.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

“Булган жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд 414.4 сая төгрөгийн суулгац, 213.1 сая төгрөгийн хашаа, 236.3 сая төгрөгийн худаг, 57.5 сая төгрөгийн усалгааны тоног төхөөрөмж, 35.0 сая төгрөгийн эрчим хүчний трансформатор, 29.9 сая төгрөгийн усалгааны систем, нийт 986.3 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгахаас Баян-Агт, Баяннуур, Бугат, Булган, Бүрэгхангай сумд нийт 146.3 сая төгрөгийн суулгац, Баяннуур, Бугат, Булган сум нийт 109.5 сая төгрөгийн худаг, Сэлэнгэ сум 10.0 сая төгрөгийн хашаа, Бугат, Сайхан сум 5.0 сая төгрөгийн хашааг тус тус бүртгэл тайланд тусгаагүй байна.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр Баян-Агт суманд хийгдсэн гүний худаг байршилыг ХХААГазар, сумдын удирдлагууд болон гүйцэтгэгч компанийн буруугаас өөр газарт гаргасан зөрчил илэрсэн. Хяналт муугаас захиалагчтай байгуулсан гэрээ, техникийн тодорхойлолтыг зөрчиж сумын төвөөс урд зүгт 5 км-ын зайтай Хагийн нуур орчимд гаргах худгийг зүүн урд зүгт 1-2 км-ыг зайтай далангийн урд гаргаж малчин иргэдэд хохирол учруулж, төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулжээ.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2016 онд 173.5 сая төгрөгийн 400 ширхэг, 2017 онд 164.8 сая төгрөгийн 400 ширхэг хогын савыг Булган сумын айл өрх, албан газруудад байрлуулж хэрэгжүүлсэн боловч бодит байдал дээр айл өрхүүд хогийг 2 төрлийн хогийн саванд дахин ашиглах болон бусад хогоор ангилан хийхгүй, мөн ангилагдсан хогийг Тохижилт үйлчилгээний анги нийлүүлж ачаад хогийн төвлөрсөн цэгт хаяж байгаа нь хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр үр дүн, үр өгөөжгүй байна. Энэ нь хог хаягдлын тухай хуулийн 9.3.1, 9.3.4, 9.3.6, 9.3.9, заалтыг

бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд хог, хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хаях ажлыг иргэдэд сурталчилан зохион байгуулах сургалт сурталчилгааны ажлыг шат дараатай хийх, мөн уг ажлыг гардан хэрэгжүүлэх тохижилт үйлчилгээний анги хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт ачиж тээвэрлэхдээ хогыг ангилан ялгалалт дээр хяналт, хариуцлага тооцдог байх ажлыг судлан хэрэгжүүлэх,

Чацарганы суулгац: “Хаан жимс эс би ти” ХХК 366187.5 мянган төгрөгийн өртөгтэй суулгацыг хавар 96875 ширхэг, намар 96875 ширхэг нийт 193750 ширхэг суулгацыг нийлүүлэхээр, “Хар хорин ” ХК 387500.0 мянган төгрөгийн өртөгтэй суулгацыг хавар 54390 ш, намар 139360 ш нийт 193750 ширхэг суулгацыг нийлүүлж 2017 онд нийт суулгацын өртөгийн 40 хувийг 2 үе шаттайгаар үлдэгдэл 60 хувийг 2018 онд санхүүжүүлэхээр тус тус гэрээ байгуулжээ.

Хөтөлбөрийн хэрэгжилтэнд орон нутгийн удирдлагуудын хяналт, шаардлага сул байна. Тухайлбал: Суулгацын захиалгыг тооцохдоо сумдуудаас ирүүлсэн хүсэлтийг харгалзан үзээгүйгээс Бүрэгхангай суманд 2000, Гурванбулаг сум 275 ш суулгацыг илүү нийлүүлсэн, Хишиг-Өндөр сум намар хүлээж авсан 20000 ш суулгацыг бүлүүд хүлээж авсан боловч одоог хүртэл тариалалтыг хийгээгүй, Чацаргана тариалах бүлүүдэд суулгацыг хүлээлгэн өгсөн боловч зарим сумдууд бүлүүдтэй гэрээ байгуулаагүй байна./Хишиг-Өндөр сум, Булган сум, Тэшиг сум гэх мэт/, Зарим сумд чацаргана тариалах талбайг газар зохион байгуулалтын төлөвлөгөөд тусгаагүй, бүлүүдэд хуваарилж өгсөн газрыг хуулийн дагуу эзэмшүүлээгүй, Сумдуудад 2018 онд хавар, намар нэмж тариалах тооцоо судалгаа одоо хүртэл байхгүй байна, Булган суманд иргэдэд хүлээлгэж өгсөн суулгацаас нийт 685 ш суулгацыг иргэн болон бүлүүдэд хүлээлгэн өгсөн нь тодорхойгүй дутагдуулсан.

Сангаар хэрэгжих төсөл арга хэмжээний төлөвлөлтөнд анхаарч, төсвийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах, зураг, төсөв, эдийн засгийн тооцоолол, хэрэгжүүлэх ажлын төлөвлөлт, хөтөлбөрийг судлан төсөвт тусгаж байх.

Төрийн сангийн авлага:

Төрийн сангийн авлага нийт 147.9 сая төгрөг байгаагаас 2001 онд үүссэн 16 жилийн насжилттай өвс тэжээлийн авлага 32, “Атрын III” аяны хүрээнд иргэдэд эргэн төлөгдөх нөхцлөөр олгосон зээлийн авлага 72.5, бусад 43.4 сая төгрөг, эдгээр авлагыг барагдуулах талаар өмнөх жилүүдийн аудитаар зөвлөмж хүргүүлж байсан ч зөвлөмжийн мөрөөр тодорхой үр дүнтэй арга хэмжээ аваагүй атрын 3-р аяны зээлээс 66.2 сая төгрөгийг барагдуулсанаас өөр өөрчлөлт ороогүй байна.

Төрийн сангийн авлагыг байгууллага бүрээр

д/д/	Нэр	он	дүн
Аймгийн төрийн сангийн авлага			
1	Баялаг компани	1997	2,369,600.00
2	Спиртийн үйлдвэр	1997	11,432,260.00

3	Чин хоршоо	1998	1,620,000.00
4	Материал импекс /Дагий дарга/	1998	498,105.00
5	ХОТШ банк	1999	507,610.00
6	Царс-Импекс	1999	11,414,239.00
7	СОНУ	1999	12,284,712.00
8	ЭТНОЗээл /Хүнсний/	1993	1,381,600.00
9	НХ-ийн төв	1999	500,000.00
10	СТ компани	2001	500,000.00
11	Д.Чулуунбат /ном/	2002	283,000.00
12	НББМ-ийн Зөвлөл /сур төл/	2002	500,000.00
13	Сумдын авсан өвсний зээл	2001	1,149,060.00
14	Атар 3 аяны зээлд олгосон	2008	72,533,527.00
	АЙМГИЙН ДҮН		116,973,713.00
Сумын төрийн сангийн авлага			
15	Баяннуур Төрийн сан	1996	4,798,700.00
16	Бугат Төрийн сан	1996	2,082,000.00
17	Сэлэнгэ Төрийн сан	1996	9,451,054.00
18	Хишиг-Өндөр Төрийн сан	1996	2,400,000.00
19	Хутаг-Өндөр Төрийн сан	1996	12,209,400.00
	СУМЫН ДҮН		30,941,154.00
	НИЙТ ДҮН		147,914,867.00

Баялаг компани: 1997 онд үүссэн. 1198.6 мянган төгрөг нь тус компани аймгийн нөөц барааны үлдэгдэл үнэ, 1171.0 мянган төгрөг нь БОК-ийн шугамаар ирсэн хивэгний үнэ бөгөөд ямар байгууллагаас авах баримт байдаггүй, эзэн холбогдогч байхгүй байна.

Сумын төрийн сангийн авлага нь Баяннуур сум 4.8, бугат 2.1, Сэлэнгэ 9.5, Хишиг-Өндөр 2.4, Хутаг-Өндөр 12.2 сая төгрөгийн нийт 30.9 сая төгрөг нь өвс, сум хөгжүүлэх сангийн зээл бөгөөд бүгд эзэн холбогдогч нь тодорхойгүй болсон авлагууд байна. Сумын санхүүжилтээс суутган авч сумдын төрийн санд авлагаар бүртгэгдсэн байна. Цаашид авлага барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулах нь зүйтэй байна.

ӨР ТӨЛБӨРИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ:

Аймгийн хэмжээнд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 589.2 сая төгрөг байснаас тайлангийн эцэст 556.8 сая төгрөг болж 32.4 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт өр төлбөрийн үлэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцийн үлдэгдэл	Зөрү ү	Хувиар
Арилжааны банк	0	4.7	4.7	1%
Ажилчидтай холбогдсон өглөг	28.3	21.6	-6.7	4%
Бараа үйлчилгээний зардлын өглөг	131.3	103.7	-27.6	19%
Байгууллагад төлөх өглөг	346.1	317.1	-41.6	55%
Хувь хүмүүст төлөх өглөг	38.9	81.8	42.9	15%
Татварын өглөг	38.4	25.0	-13.1	5%
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	6.2	2.9	2.9	2%
Нийт	589.2	556.8	32.4	

Нийт өр төлбөрийн 58 хувь нь төсөвт байгууллага, 41 хувь нь орон нутгийн үйлвэрийн газар, 1 хувь нь төрийн сангийн өр төлбөр эзэлж байна.

Сум, тосгоны дүнгээр өглөг нийт 32.4 сая төгрөгөөр буурсан ч Баян-Агт сум 2.3, Булган аймаг 38.5, Сэлэнгэ сум 11.3, Хишиг-Өндөр сум 1.2, Хутаг-Өндөр сум 2.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Б.2. Системийг хэрэглэхэд ойлгомжтой, шаардлагатай үйл ажиллагааны хамрах хүрээг хамарч чадсан хэдий ч гар ажиллагаа их шаардлагатай, сарын сүүл болон эхээр ачаалал нь ихэсч гацдаг дутагдал байна.

Б.2.1 Аймагт төрийн сангийн мэргэжилтэн, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн, сумдад Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэнүүд ЗГСУМС-ийг ашиглаж байна.

Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем хэрэглэгчдээс авах судалгаа, санал асуулгаас үзэхэд шинэчлэгдсэн “V7” программ өмнөх Freebalance”-ийг бодвол ажиллагаа их шаардагддаг, ЗГСУМС-г хэрэглэж байхад гэнэт программаас гарах, хадгалахад алдаа заадаг, зарим үед системийн саатал гарч гүйлгээ хийхэд хүндрэлтэй, сарын сүүлчээр болон сарын эхээр гүйлгээ хаах мэдээ гаргах үед систем гацаад ажилладаггүй зэрэг асуудлууд байна.

Мөн “V7” программ нь компьютерийн хүчин чадал ихээхэн шаарддаг, зарим сумдын санхүү албаны тоног төхөөрөмжийн хүчин чадал хүрэлцдэггүй гэсэн санал байна. Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх шаардлага байна ялангуяа тог баригч, суурын Dell компьютерийг 2005-2007 онд ашиглалтанд орсон одоог хүртэл 11 дэх жилдээ ашиглаж байна.

Б.2.2. Мэдээллийн систем болон тоног төхөөрөмжийн аюулгүй байх орчин нөхцөл тодорхой хэмжээгээр хангагдсан байна.

Төрийн сангийн нэгдсэн тогтолцооны мэдээллийн системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчдийн ажил үүргийн хуваарь, тэдгээрийн систем дээр хийгдэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Сангийн сайдын 2014 дны 95 дугаар тушаалын хавсралтанд заасан “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-аар зохицуулагддаг.

ЗГСУМС-ийн хэрэглэгчид нь аймагт еранхий нягтлан бодогч, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн, төрийн сангийн мэргэжилтэн ашигладаг бол сумдад санхүүгийн албаны дарга, төрийн мэргэжилтэнүүд нь ЗГСУМС-ийн журамд заагдсан чиг үүргийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст ашиглаж байгаа программд нэвтрэх эрхтэй 16 сум нэг тосгоны 34 хэрэглэгч аймгийн төрийн сангийн 4 хэрэглэгч байдаг. Эдгээр нэвтрэх эрх бүхий хэрэглэгчдийн хийж гүйцэтгэх ажлын хуваарь, оролцоог дээр дурьдсан журмаар зохицуулжээ.

Тус газар нь Мэдээлэл, холбоо сүлжээ ХХК-ий Булган салбараас сүлжээ авдаг бөгөөд дамжуулах төхөөрөмж нь тусгай зориулалтын техникийн өрөөнд, зориулалтын цоожтой хайрцагт байрладаг, өрөөнд гадны хүн орохыг хориглодог ба зайлшгүй шаардлагаар орох тохиолдолд ерөнхий инженерийн зөвшөөрлөөр нэвтэрдэг байна. Ингэхдээ хаанахын ямар байгууллагаас хэн гэдэг, ямар албан тушаалын хүн орсныг бүртгэлийн дэвтэрт бүртгэдэг байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст мэдээлэл технологийн ажилтан байдаггүй бөгөөд Сангийн яамны санхүүгийн мэдээлэл технологийн хэлтсээс мэргэжилтэн ирж тоног төхөөрөмжийн гэмтэл засах солих ажил хийж байна.

Эдгээрээс үзэхэд мэдээллийн систем болон тоног төхөөрөмжийн аюулгүй байх орчин нөхцөл тодорхой хэмжээгээр хангагдсан гэж үзлээ.

ЗГСУМС-ийг ашигладаг мэргэжилтнүүдээс авсан санал асуулга болон ярилцлагаас үзэхэд програмд ачаалал үүсэх, зарим үед тасалдах, гацах гэх мэт хүндрэл үүсдэг байна.

Дээрх хүндрэлүүд нь ажил, гүйлгээ хугацаандаа хийгдэхгүй байх, төрийн сангийн мэргэжилтнүүдийн ажлын ачааллыг нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдийг чирэгдүүлэх гэх мэт эрсдлүүдийг дагуулж байна. Сүлжээний тоног төхөөрөмжийн хувьд аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ий Булган аймаг дахь салбарын байранд тус тус суурлиуулан сүлжээнд холбогддог байна.

Б.3. Төрийн сангийн дотоод хяналтаар илэрсэн алдаа зөрчил аудитын явцад дахин давтан гарч байна.

Б.3.1 Аймгийн СТСХ нь аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/20 тоот захирамжаар дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө батлуулж төсвийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан заавар, журмын хэрэгжилтийг

хянах, төсвийн төлөвлөлт, түүний зарцуулалт, төсвийн өр авлага, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, зарцуулалт, төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж зөвлөн туслах чиглэлээр Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд 13 сум, 1 тосгонд 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 14-ний хооронд ажилласан байна. Ингэхдээ төлөвлөгөөнд багтсан Бугат, Орхон сумыг хамруулаагүй байна

2017 онд хийсэн дотоод хяналтаар төрийн сангийн эрсдэлийн нэгдсэн үнэлгээний нийт оноогоор Бүрэгхангай, Орхон сумд 41-ээс дээш буюу “өндөр” эрсдэлтэй, Баян-Агт, Баяннуур, Бугат, Булган, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумд, Хялганат тосгоны төрийн сан, аймгийн төрийн сан 21-40 буюу “дунд”, Могод сум 20-оос бага буюу бага эрсдэлтэй тооцогдсон байна.

Монгол улсын сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 65 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 5.1.3 дахь “Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан эрх бүхий албан тушаалтан төрийн сангийн нэгжийн эрсдэлийн түвшний зураглал /хавсралт 4/-д 3 болон түүнээс дээш оноотой хэсэгт байрласан тохиолдолд дотоод хяналтанд зайлшгүй хамруулна.” гэж заасан боловч төрийн сангийн нэгжийн эрсдэлийн түвшний зураглал хийж хэвшээгүй байна.

Дотоод хяналтыг 2017 онд

- Төсвийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан заавар, журмын хэрэгжилтийг хянах,
- Төсвийн төлөвлөлт, түүний зарцуулалт, Төсвийн өр авлага,
- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, зарцуулалт,
- Төрийн сангийн үйл ажиллагаа гэсэн чиглэлээр хяналт хийж 13 сум, 1 тосгонд тайлан хүргүүлэн алдаа дутагдалтай байгаа ажил тус бүрт зөвлөмж өгч ажилласан байна.

Сумдын тайлангаас үзэхэд орон нутгийн орлого, зарлага, төсвийн төсөл, төсөл хэлэлцсэн байдал, Засаг даргын нөөц хөрөнгө, орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС, СХС, БХС, байгууллага бүрийн шилэн данс, төсвийн зарцуулалт, төрийн сангийн дотоод үйл ажиллагаа буюу эрх шилжүүлэлт, гарын үсгийн баталгааны бүрдэл, ЗГСУМС-д мөрдөх журмын хэрэгжилт, аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, аймгийн дэд хөтөлбөрт багтсан “Зөв бүртгэл” хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал зэргийг хянаж тус бүрт алдаа дутагдлыг үнэлэн зөвлөмж өгч ажилласан байна.

Төрийн сангийн төлбөр тооцоонд тавих хяналтыг сумдад хэрэгжүүлсэн ч гарсан алдаа зөрчлийг тухай бүр нь зөвлөмж өгч ажиллаж байгаа ч хэрэгжилтийг эргэн тооцдоггүйгээс аудитын явцад дотоод хяналтаар гарсан зөрчилүүд арилахгүй дахин

давтан гарч байгаа нь дотоод хяналтаар зөрчлийг арилгах талаар өгсөн зөвлөмж зааврын хэрэгжилт хангалтгүй байна гэж үзлээ.

Б.3.2. Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6 дахь “Төв төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төрийн захиргаааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ” гэж заажээ.

Аймгийн СТСХ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт аймгийн төсөв санхүүг хариуцлагатай, ил тод, үр ашигтай удирдаж, орон нутгийн хөгжлийг дэмжинэ гэж тусгасан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Зөв бүртгэл” хөтөлбөрийг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан хэрэгжүүлж байна. Төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд оршиж буй зөрчил дутагдлыг арилгах, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор аймгийн төвийн зарим төсөвт байгууллагуудын шатахуун, томилолтын зарцуулалтанд хяналт хийжээ.

“Суудлын автомашины ашиглалтын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 05 сарын 11-ны өдрийн 184 дугаар тогтоол, “Төрийн сангийн үйл ажиллагааны журам” батлах тухай Засгийн газрын 2015 оны 01 сарын 26-ны өдрийн 24 дугаар тогтоол, “Заавар батлах тухай” Сангийн сайдын 2016 оны 12 сарын 26-ны өдрийн 431 дугаар тушаал, төсөв захирагчийн 2017 оны батлагдсан төсвийг үндэслэл болгосон байна.

Аймгийн Засаг даргаар батлуулсан зөвлөмжийн дагуу 2017 оны 10-р сарын 09-нээс 11-р сарын 1-ний хооронд орон нутгийн төсвийн шууд харьяа байгууллага болох аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ, Байгаль орчны газар, Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт аудитын алба, Биеийн тамир спортын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, ГБХЗХГ, Номын сан, Музей, ХЖТ-ын томилолт, шатахууны зардлын гүйцэтгэлд эхний 9 сарын байдлаар хяналт хийжээ.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд дүнг танилцуулж, хурлаас өгсөн чиглэлийн дагуу улсын төсвийн байгууллага болох Боловсрол соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Цэргийн штаб, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Хүнс хөдөө аж ахуйн газрын томилолт, шатахууны зардлын 2017 оны гүйцэтгэлд дотоод хяналт хийсэн байна.

Хяналт шалгалтаар илэрсэн асуудлаас дурьдвал:

1. Төсөвт байгууллагуудын жолоочийн тооцооны хуудсаас харахад дотор үйлчилгээнд шатахуун их зарцуулж, яг ямар ажлаар дотор явсан нь тодорхойгүй байсан. Тэр тусмаа хувийн автомашинаар дотор үйлчилгээнд явж байгаа нь хардлага төрүүлдэг. Иймд аль болох шаардлагагүй тохиолдолд дотор явахгүй байх,

явсан тохиолдолд ямар ажил үйлчилгээнд явсан тайланг замын хуудсанд заавал хавсаргаж байхыг төсөв захирагч нарт хүргүүлэх зөвлөмжинд тусгасан.

2.Боловсрол соёл урлагийн газар томилолтын зардлыг хичээл үйлдвэрлэлийн зардлаасаа гаргасан байна. Хичээл үйлдвэрлэлийн зардлаас төсөвт байгууллагын албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах, дадлага сургуулилт хийлгэх зорилгоор гадаад, дотоодод сургалт, семинарт хамруулах болон эдгээр зорилгоор нэгдсэн семинар, сургалт, хурал зөвлөгөөн зохион байгуулахад шаардагдах сургалтын төлбөр, унаа, хоолны зардал, сургалттай холбоотой материал зэргийг гаргана гэсэн заалтын дагуу зарим томилолтын зардлыг гаргасан байна.

3. Аймгийн ЗДТГ-ын хувьд шатахууны зардал хэтэрч байгаад анхаарч оны эхнээс ажлыг нарийвчлан төлөвлөж, тооцоолсон байх шаардлагатай байна гэсэн дүгнэлт зөвлөмжийг гаргасан байна.

Мөн аймгийн төсвийн гүйцэтгэлийг ИТХ-ийн тэргүүлэгчдийн хурлаар улирал бүр оруулж орлогын бүрдүүлэлт, зарлага, санхүүжилт гэсэн хэлбэрээр хуралд хэлэлцүүлдэг байна.

ДҮГНЭЛТ:

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Сумдад хэрэгжиж байгаа ОНХС, СХС, ЖДҮДС, БХ сан зэрэг сангуудыг бүртгэл тайлагнал зэргийг Засгийн газрын болон сангийн сайдын тушаалд санхүүгийн албаны ажлын чиг үүрэгт нягтлан бодогч хариуцахаар тусгасан ч Тэшиг, Баяннуур сумдууд төрийн сангийн мэргэжилтэн, Сэлэнгэ, Хангал, Хишиг-Өндөр сум, Хялганат тосгоны Санхүүгийн албаны дарга 2 дугаар гарын үсэг зурж бүртгэл тайлагналыг хариуцдаг нь Засгийн газрын 326 дугаар тогтоолоор баталсан ажлын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаагүй.
- Аймгийн СТСХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч нар ОНХС, ОНХО, авто замын сан, төсвийн мэргэжилтэн байгаль хамгаалах сангийн 2 дугаар гарын үсэг зурж байгаа нь дотоод хяналтыг алдагдуулсан,
- Төрийн санд төсөв захирагчийн гарын үсэггүй, байгууллагын тамга тэмдэг дараагүй, нягтлан бодогчийн гарын үсэггүй төлбөр тооцооны маягтаар гүйлгээг хийсэн,
- Төрийн сангийн зарлагын жагсаалтыг Бугат, Сэлэнгэ сумдууд дараа сард, Хангал, Хялганат тосгон 10 хоногт тулган хянадаг,
- Сум хөгжүүлэх сангийн зээл 2017 оны эцэст 546 иргэний 1766.5 сая төгрөгийн эргэн төлөлт хугацаа хэтрэлттэй аймгийн хэмжээнд 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө эдийн засгийн эргэлтэнд ороогүй,
- Төсвийн тухай хуулийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ

хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчин хэзээ, хэрхэн, юунд зарцуулах нь тодорхойгүй шаардлагатай үед зарцуулах зардалд 78.2 сая төгрөгийг БХС-гаас зарцуулахаар тус тус төлөвлөн баталсан,

- Зөв бүртгэл хөтөлбөрийг хэрэгжүүлснээр НББ-ийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээний ахиц гарсан байна.
- Төрийн сангийн төлбөр тооцоонд тавих хяналтыг сумдад хэрэгжүүлэн гарсан алдаа зөрчлийг тухай бүр нь зөвлөмж өгч ажиллаж байгаа ч хэрэгжилтийг эргэн тооцдоггүй зэргээс төрийн сангийн тогтолцоонд хэрэгжүүлж байгаа журам, зааврыг бүрэн мөрдөн ажиллаагүй, төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Д.Батцогт, ерөнхий нягтлан бодогч О.Сайнзаяа нарт:

1. Сумдын санхүүгийн албаны ажлын чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтод тусгасан ажлуудыг Засгийн газрын 326 дугаар тогтоолоор баталсан санхүүгийн албаны чиг үүрэгтэй нийцүүлэх.
2. Төрийн санд төлбөр тооцоог хийхэдээ гарын үсгийн бүрдэл, хүчин төгөлдөр баримтаар гүйцэтгэж байх.
3. Төрийн сан өдөр тутмын төлбөрийн баримтыг тухай өдрийн зарлагын гүйлгээний жагсаалттай дараагийн ажлын өдөрт багтаан хянаж тулгаж хэвших.
4. Төсөл сангуудын авлага болон төрийн сангийн авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулах.
5. Төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө зураг төсөв, ТЭЗҮ хийгдээгүй ажлыг төсөвт тусгахгүй байх.
6. Төрийн сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтаар илэрсэн алдаа, зөрчил дахин давтан гарсаар байгааг анхаарч, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт хийж байх.

САНАЛ:

- Төсвийн тухай хуулинд аймаг нийслэл, сум дүүргийн төрийн сангийн бүтцийг зааж өгсөн боловч тосгоны төрийн сангийн тогтолцоо, нэгжийн бүтцийг хуульчилж өгөөгүй байна.
- Хялганат тосгон нь санхүүгийн албаны ерөнхий зохион байгуулалт, чиг үүргийг барьж ажиллаж байгаа хэдий ч орон нутгийн байгууллагуудыг хариуцсан нягтлан бодогч нь эрүүл мэндийн төвийг хариуцан захирагчийн

ажлын албаны төсөвт багтдаг, тусгай зориулалтын шилжүүлгийн нягтлан бодогч нь ерөнхий боловсролын сургуулийн төсвөөс цалин авч захирагчийн ажлын албанд харьяалагдан ажиллаж байгаа нь тосгонд төрийн сан, санхүүгийн алба байх эсэх талаар хууль журамд тусгаагүй учир чиг үүрэг нь тодорхойгүй байна.

- Аймгийн орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалт, байгаль хамгаалах сан, авто замын сан зэрэг сангуудын бүртгэл тайлагналыг хэн хариуцах талаар чиг үүрэгт тодорхой тусгах.
- Сумдын санхүүгийн алба жишиг орон тоогоор 4 байгаа боловч сумын бүртгэл тайлагналын ажил 2 нягтлан бодогч дээр төвлөрч, нэг нягтлан бодогч 3-4 байгууллага, сангуудыг хариуцаж байгаа нь ажлын үр дүн, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа чанаргүй болж сөрөгөөр нөлөөлж болзошгүй байгаа тул нягтлан бодогчийн орон тоог нэмэгдүүлэх.

Мэдэгдэл:

Санхүүгийн аудитаар илэрсэн зөрчлийг арилган, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт гарсан үр дүнгийн талаар 2018 оны 12 дугаар сарын 20-ний дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ

АУДИТОР

Д.ДААРИЙМАА

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын
2018 оны 11 дугаар сарын 05-ний өдрийн
А/19 тоот тушаалын хавсралт

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТААР
ИЛЭРСЭН ТӨЛБӨР ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

№	Хариуцах эзэн	Албан тушаал	Акт, албан шаардлагын дугаар	Төлбөр зөрчлийн товч утга	Төлбөр зөрчлийн нийт дүн	Үүнээс			
						Акт	Албан шаардлага	Аудитын явцад барагдуулсан	
								Төлбөр	Зөрчил
1	Х.Ууганбаяр, Г.Лхагважаргал	Бугат сумын ЗДТГ-ын дарга, Санхүүгийн албаны дарга	САГ-2018-03-CA-01/44	Гарын үсгийн бүрдэл болоогүй гүйлгээ хийсэн	3885639.00		3885639.00		
2	Ц.Ууганбаяр, М.Энхбат	Сэлэнгэ сумын ЗДТГ-ын дарга, Санхүүгийн албаны дарга	САГ-2018-03-CA-02/45	Гарын үсгийн бүрдэл болоогүй гүйлгээ хийсэн, системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчид эзлэгийн амралттай, түр чөлөөтэй үед программд нэвтрэх нэр, нууцийг журмын дагуу шилжүүлээгүй, Төсвийн мэргэжилтэний хийсэн төлбөр тооцоог санхүү албаны дарга гүйлгээний тамга дарж баталгаажуулдаг	27810901.00		27810901.00		
3	Х.Мөнх-Алтай	Могод сумын Санхүүгийн албаны дарга	САГ-2018-03-CA-03/46	Гарын үсгийн бүрдэл болоогүй гүйлгээ хийсэн	11755015.00		11755015.00		
4	П.Должинсүрэн	Гурванбулаг сумын Санхүүгийн албаны дарга	САГ-2018-03-CA-04/47	Гарын үсгийн бүрдэл болоогүй гүйлгээ хийсэн	37448709.00		37448709.00		
5	Д.Энхчимэг	Хишиг-Өндөр сумын Санхүүгийн албаны дарга	САГ-2018-03-CA-05/48	Гарын үсгийн бүрдэл болоогүй гүйлгээ хийсэн	2405823.00		2405823.00		
6	Л.Туяа, Ц.Бат-Ирээдүй	Булган сумын ЗДТГ-ын дарга, Санхүүгийн албаны дарга	САГ-2018-03-CA-06/58	Гарын үсгийн бүрдэл болоогүй гүйлгээ хийсэн	89941449.00		89941449.00		
Нийт төлбөр зөрчлийн дүн					173247536.00	-	173247536.00	0	0

ЖАГСААЛТ ГАРГАСАН:

АУДИТОР *Х.Харуучинмаа* ДДАРИЙМАА



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АЛБАН ШААРДЛАГА**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2018.09.27 № САГ-2018-03-24

Танай _____-ны № _____ Т

СЭЛЭНГЭ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Ц.УУГАНБАЯР ТАНАА

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд хийсэн санхүүгийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, байгаль хамгаалах сан, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн төлбөр тооцоо хийх эрх бүхий албан тушаалтаны гарын үсгийн баталгаа хийгээгүй төрийн сангаас төлбөр гүйцэтгэсэн, төсвийн зарлагын гүйлгээний жагсаалтыг сард нэг удаа тулган баталгаажуулдаг, байгууллагын даргын тамга тэмдэг, гарын үсэггүй 5 гүйлгээний 3237.0, нягтлан бодогчийн гарын үсэггүй 24537.0 мянган төгрөгийн гүйлгээг хийсэн, системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчид ээлжийн амралттай, түр чөлөөтэй үед программд нэвтрэх нэр, нууцийг журмын дагуу шилжүүлээгүй, Төсвийн мэргэжилтэний хийсэн төлбөр тооцоог санхүү албаны дарга гүйлгээний тамга дарж баталгаажуулдаг зэрэг зөрчил илэрлээ.

Дээрх зөрчил нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.3, 7.13.5, 8.6, 11.1, 12.2, Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд мөрдөх журмын 2.4 дэхь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх.."Монгол улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

Дээрх зөрчлийг журмын дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангуулах арга хэмжээ авч 2018 оны 10 дугаар сарын 20-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Засаг даргын тамгын газрын дарга Ц.Ууганбаяр, Санхүүгийн албаны дарга М.Энхбат нарт хариуцуулан даалгав.



АЛБАН ШААРДЛАГЫГ



* Акт албан шаардлагын биелэлт хангаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд илгээл хийгүүлнэ



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АЛБАН ШААРДЛАГА**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2018.10.11 № САГ-2018-03-СА-09/46

Танай _____-ны № _____ т

МОГОД СУМЫН САНХҮҮГИЙН
АЛБАНЫ ДАРГА Х.МӨНХ-АЛТАЙ
ТАНАА

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон аймгийн Аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Могод сумын 2017 оны төрийн сангийн мемориалын баримтыг үзэхэд байгууллагын нягтлан бодогчийн гарын үсэггүй 7 гүйлгээний 11475.0 мянган төгрөгийн гүйлгээ, төрийн сангийн тамга гарын үсэг зурж баталгаажуулаагүй 1 гүйлгээний 280.0, нийт 11755.0 мянган төгрөгийн гарын үсгийн бүрдэл болоогүй гүйлгээ хийсэн байна.

Дээрх зөрчил нь Засгийн газрын 2012 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.13, 7.13.5, 8.6 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..” Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д “...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Дээрх зөрчлийг арилгаж анхан шатны баримтын бүрдлийг хангуулах арга хэмжээ авч албан шаардлагын биелэлтийг 2018 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг сумын Санхүү албаны даргад даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ӨГСӨН²:

АУДИТОР

Х.Дариймаа Д.ДААРИЙМАА

6317/144/95
ГЮА0048 313020

ЗӨВШӨӨРСӨН:

САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА
Х.Мөнх-Алтай Х.МӨНХ-АЛТАЙ

² Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналгүйг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АЛБАН ШААРДЛАГА

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН САНХҮҮГИЙН
АЛБАНЫ ДАРГА Д.ЭНХЧИМЭГ
ТАНАА

2018.10.11 № САГ-2018-03-СА-05/48
Танай _____-ны № _____ Т

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон аймгийн Аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хишиг-Өндөр сумын 2017 оны төрийн сангийн мемориалын баримтыг үзэхэд байгууллагын тамга тэмдэг, гарын үсэггүй 2 гүйлгээний 70.8, байгууллагын нягтлан бодогчийн гарын үсэггүй 5 гүйлгээний 1674.1 мянган төгрөгийн гүйлгээ, төрийн сангийн тамга гарын үсэг зурж баталгаажуулаагүй 1 гүйлгээний 660.9, нийт 2405.8 мянган төгрөгийн гарын үсгийн бүрдэл болоогүй гүйлгээ хийсэн байна.

Дээрх зөрчил нь Засгийн газрын 2012 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7.13, 7.13.5, 8.6 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх." Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "... дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Дээрх зөрчлийг арилгаж анхан шатны баримтын бүрдлийг хангуулах арга хэмжээ авч албан шаардлагын биелэлтийг 2018 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг сумын Санхүү албаны даргад даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ӨГСӨН:

АУДИТОР Д.ДААРИЙМАА

ЗӨВШӨӨРСӨН:

САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА
Д.ЭНХЧИМЭГ

² Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хувацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АЛБАН ШААРДЛАГА

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2018.10.11 № САГ-2018-03-СА-04/47

Танай _____-ны № _____ т

ГУРВАНБУЛАГ СУМЫН САНХҮҮГИЙН
АЛБАНЫ ДАРГА П.ДОЛЖИНСҮРЭН
ТАНАА

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон аймгийн Аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гурванбулаг сумын 2017 оны төрийн сангийн мемориалын баримтыг үзэхэд байгууллагын тамга тэмдэг, гарын үсэггүй 13 гүйлгээний 8380.6, байгууллагын нягтлан бодогчийн гарын үсэггүй 12 гүйлгээний 26537.7, төрийн сангийн тамга гарын үсэг зурж баталгаажуулаагүй 1 гүйлгээний 2530.3, нийт 37448.6 мянган төгрөгийн гарын үсгийн бүрдэл болоогүй гүйлгээ хийсэн байна.

Дээрх зөрчил нь Засгийн газрын 2012 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.13, 7.13.5, 8.6 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх.” Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д “... дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

Дээрх зөрчлийг арилгаж анхан шатны баримтын бүрдлийг хангуулах арга хэмжээ авч албан шаардлагын биелэлтийг 2018 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг сумын Санхүү албаны даргад даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ӨГСӨН²:

АУДИТОР

Д.ДААРИЙМАА

ЗӨВШӨӨРСӨН:

САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА
П.ДОЛЖИНСҮРЭН

² Акт албан шаардлагын биелэлт хангаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АЛБАН ШААРДЛАГА**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2018.09.25 № САГ-2018-03-СА

Танай _____-ны № _____ т

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд хийсэн санхүүгийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Төсвийн зарлагын гүйлгээний жагсаалтыг байгууллага бүрээр сард нэг удаа тулган баталгаажуулдаг, ИТХ-ын 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 6 төрлийн 2716.0 мянган төгрөгийн гүйлгээг 06 дугаар сарын 23-ны өдөр хугацаа хэтрүүлэн гүйцэтгэсэн, нягтлан бодогчийн гарын үсэггүй 4 гүйлгээний 1169.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг хийсэн зөрчил илэрсэн.

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 11.1 дэхь "Төрийн сан өдөр тутмын төлбөрийн баримтыг тухайн өдрийн зарлагын гүйлгээний жагсаалттай дараагийн ажлын өдөрт багтаан хянаж тулгасан байна." 8.10 дахь "Төсвийн байгууллагын ТТ-1, ТТ-2 маягтаар бичигдсэн төлбөрийн хүсэлт нь бичигдсэн өдрийг оролцуулан ажлын 3 хоногт хүчинтэй", 7.13 дэхь "дараах тохиолдолд зарлагын гүйлгээ гаргахыг хориглоно.", 7.13.5 дахь "энэхүү журмын 7.1, 7.2, 7.3-т заасан бүрдэл болоогүй гарын үсгээр гүйлгээ хийх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх." Монгол улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Дээрх зөрчлийг журмын дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангуулах арга хэмжээ авч 2018 оны 10 дугаар сарын 20-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн сумын Засаг дарга Х.Ууганбаяр, санхүүгийн албаны дарга Г.Лхагважаргал нарт хариуцуулан даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
АУДИТОР
П.СОДНОМ

ЗӨВШӨӨРСӨН:
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Х.УУГАНБАЯР
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА
Г.ЛХАГВАЖАРГАЛ

*Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил заргасан албан тушаалтныг уурзарт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтныг хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.